# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код:** УВА-2022/68/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Увс аймгийн Улаангом сум<br>2022 он | Цахим хуудас: uvs@audit.gov.mn<br><br>Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317<br>Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799<br>Цахим хаяг:Bat-Amgalanm@audit.gov.mn<br><br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн “Увс Финанс аудит” ХХК аудитор: С.Цэрэнминжин<br>Утас: 99458717<br>Цахим хаяг: enhee_ja@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан ... 7
   3.1 Ерөнхий зүйл ... 9
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ... 9
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 10
   3.4 Материаллаг байдал ... 10
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ... 11
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 11
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ... 12
   3.8 Аудитын гол асуудал ... 12
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 12
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 13
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 13
4. Аудитын илрүүлэлт ... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ... 14


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.15 № УвА-2022/68/НА-СТА-ТҮ43
танай____________-ны №______________-т

ТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Х.БЯМБАЖАВ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР [signature] Д.ЖАМБАТСУУРЬ

0200200496

## 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,273,302.00 | 1,764,374.00 |
| 33 | АВЛАГА | 40,702.00 | 56,774.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 40,702.00 | 56,774.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,232,600.00 | 1,707,600.00 |
| 354 | Хангамжийн материал | 1,232,600.00 | 1,707,600.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 315,000.00 | 230,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 782,600.00 | 1,359,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 135,000.00 | 118,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 6,976,286.80 | 17,026,905.68 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 6,976,286.80 | 17,026,905.68 |
| 392 | Биет хөрөнгө | 6,976,286.80 | 17,026,905.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 13,753,000.00 | 14,636,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -8,970,899.86 | -8,229,499.74 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,941,750.00 | 16,263,400.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,747,563.34 | -5,642,994.58 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 8,249,588.80 | 18,791,279.68 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,249,588.80 | 18,791,279.68 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 8,249,588.80 | 18,791,279.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,032,600.00 | 1,032,600.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,032,600.00 | 1,032,600.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 7,216,988.80 | 17,758,679.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,216,988.80 | 7,216,988.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 10,541,690.88 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 8,249,588.80 | 18,791,279.68 |

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 84,871,700.00 | 108,379,200.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 00.00 | 10,973,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 10,973,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 10,973,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 10,973,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 84,871,700.00 | 97,406,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилттах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 500,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 84,871,700.00 | 96,906,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,871,700.00 | 96,906,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 84,204,634.88 | 97,825,009.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 84,204,634.88 | 97,825,009.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 83,305,901.88 | 88,867,622.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 58,884,222.00 | 61,102,756.00 |
| 210101 | Үндсэн цалин | 33,778,832.00 | 36,386,894.00 |
| 210104 | Урамшуулал | 25,105,390.00 | 24,715,862.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7,957,465.00 | 8,332,075.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,416,065.00 | 6,070,589.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 295,400.00 | 385,371.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 236,400.00 | 308,297.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 797,073.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,009,600.00 | 770,742.56 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,146,800.00 | 9,494,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 680,000.00 | 815,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,046,800.00 | 8,044,350.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 420,000.00 | 369,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 266,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 150,000.00 | 1,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,000.00 | 1,200,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 250,000.00 | 218,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 144,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 74,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,787,414.88 | 8,520,441.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 4,084,660.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,147,900.00 | 2,553,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,639,514.88 | 1,882,381.12 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 898,733.00 | 8,957,387.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 200,000.00 | 7,679,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 6,313,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 1,366,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 698,733.00 | 1,277,587.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 698,733.00 | 1,277,587.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 667,065.12 | 10,554,190.88 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 12,500.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 12,500.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | -12,500.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 667,065.12 | 10,541,690.88 |

**2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 84,871,700.00 | 97,406,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 84,871,700.00 | 97,406,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 500,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 84,871,700.00 | 96,906,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,871,700.00 | 96,906,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 84,871,700.00 | 97,406,200.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 84,871,700.00 | 97,406,200.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 83,972,967.00 | 88,448,813.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 59,020,359.00 | 61,102,756.00 |
| 210101 | Үндсэн цалин | 33,914,969.00 | 36,386,894.00 |
| 210104 | Урамшуулал | 25,105,390.00 | 24,715,862.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7,990,808.00 | 8,348,147.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,449,408.00 | 6,086,661.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 295,400.00 | 385,371.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 236,400.00 | 308,297.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 797,073.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,009,600.00 | 770,742.56 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,561,800.00 | 7,842,910.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 840,000.00 | 698,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,046,800.00 | 6,567,910.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 420,000.00 | 369,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 255,000.00 | 208,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,800,000.00 | 1,490,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,800,000.00 | |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,490,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 150,000.00 | 1,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,000.00 | 1,200,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 250,000.00 | 218,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 144,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 74,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,200,000.00 | 8,247,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 4,859,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх | 1,200,000.00 | 3,387,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 898,733.00 | 8,957,387.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 200,000.00 | 7,679,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 6,313,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 1,366,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 698,733.00 | 1,277,587.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 698,733.00 | 1,277,587.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

**2.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,032,600.00** | **00.00** | **7,884053.92** | 8,916,653.92 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 667,065.12 | 667,065.12 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,032,600.00** | **00.00** | **7,216,988.80** | 8,249,588.80 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,032,600.00** | **00.00** | **7,216,988.80** | 8,249,588.80 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,032,600.00** | **00.00** | **7,216,988.80** | 8,249,588.80 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 10,541,690.88 | 10,541,690.88 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,032,600.00** | **00.00** | **17,758,679.68** | 18,791,279.68 |

**2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 96,906,200.00 | 95,628,613.00 | 1,277,587.00 | 99% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 96,906,200.00 | 95,628,613.00 | 1,277,587.00 | 99% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 89,226,400.00 | 87,948,813.00 | 1,277,587.00 | 99% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 62,057,300.00 | 61,102,756.00 | 954,544.00 | 98% |
| 210101 | Үндсэн цалин | 36,951,300.00 | 36,386,894.00 | 564,406.00 | 98% |
| 210104 | Урамшуулал | 25,106,000.00 | 24,715,862.00 | 390,138.00 | 98% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,349,200.00 | 8,348,147.00 | 1,053.00 | 100% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,980,700.00 | 6,086,661.88 | -105,961.88 | 102% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 592,200.00 | 385,371.28 | 206,828.72 | 65% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 473,700.00 | 308,297.30 | 165,402.70 | 65% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 118,400.00 | 797,073.98 | -678,673.98 | 673% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,184,200.00 | 770,742.56 | 413,457.44 | 65% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,850,400.00 | 7,842,910.00 | 7,490.00 | 100% |
| 210401 | Бичиг хэрэг | 699,700.00 | 698,000.00 | 1,700.00 | 100% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,568,000.00 | 6,567,910.00 | 90.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 374,600.00 | 369,000.00 | 5,600.00 | 99% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 208,100.00 | 208,000.00 | 100.00 | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,499,400.00 | 1,490,000.00 | 9,400.00 | 99% |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,490,000.00 | -1,490,000.00 | 0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 720,400.00 | 700,000.00 | 20,400.00 | 97% |
| 210702 | Дотоод албан томилолт | 720,400.00 | 700,000.00 | 20,400.00 | 97% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 483,400.00 | 218,000.00 | 265,400.00 | 45% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 144,000.00 | 72,000.00 | 67% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 74,000.00 | 74,000.00 | 0.00 | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8266300.00 | 8247000.00 | 19,300.00 | 100% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,866,700.00 | 4,859,600.00 | 7,100.00 | 100% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,399,600.00 | 3,387,400.00 | 12,200.00 | 100% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7679800.00 | 7679800.00 | 0.00 | 100% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,679,800.00 | 7,679,800.00 | 0.00 | 100% |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,200.00 | 6,313,200.00 | 0.00 | 100% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,366,600.00 | 1,366,600.00 | 0.00 | 100% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 96,906,200.00 | 96,906,200.00 | 0.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 96,906,200.00 | 96,906,200.00 | 0.00 | 100% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 96,906,200.00 | 96,906,200.00 | 0.00 | 100% |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 12 | 12 | 0.00 | 100% |
| 620001 | Удирдах ажилтан | 11 | 11 | 0.00 | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 1 | 1 | 0.00 | 100% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | | | |

**2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **500,000.00** | **500,000.00** | **0.00** | 100% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **500,000.00** | **500,000.00** | **0.00** | 100% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | 100% |
| 210702 | Дотоод албан томилолт | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | 100% |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 500000.00 | 500000.00 | **0.00** | 100% |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | 100% |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | 100% |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | **0.00** | #DIV/0! |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Увс Финанс Аудит" ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Увс Финанс Аудит" ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 84,204.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,684.0 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 97,825.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,956.5 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцох хувийг 80 хувиар тооцож 1,565.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,106.2 мянган төгрөгөөр буюу 3.6 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс, бараа материал, өр төлбөр данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 40,702.00 | 56,774.00 | 16,072.00 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 1,232,600.00 | 1,707,600.00 | 475,000.00 |
| Үндсэн хөрөнгө | 6,976,286.80 | 17,026,905.68 | 10,050,618.88 |
| **Нийт хөрөнгө** | 8,249,588.80 | 18,791,279.68 | 10,541,690.88 |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 8,249,588.80 | 18,791,279.68 | 10,541,690.88 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 8,249,588.80 | 18,791,279.68 | 10,541,690.88 |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 16.0 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,707.6 мянган төгрөг болж 475.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан, үнэ төлбөргүй ирсэн аж ахуйн материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,026.9 мянган төгрөг болж 10,050.6 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 18,791.3 мянган төгрөг болж 10,541.6 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө, бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 23,507.5 мянган төгрөгөөр буюу 26.7 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хөрөнгө ирсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 13,620.3 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна. Энэ нь цалин, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, томилолт, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна. Өмнөх онтой харьцуулахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, албан хаагч нэг удаагийн тэтгэмж зардал шинээр төлөвлөсөн.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 107,008.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 107,008.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10,102.1 мянган төгрөгөөр бууруулж 96,906.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хурал семинарын төлөвлөсөн зардал хасагдсантай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 96,906.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 96,906.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 96,906.2 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 96,906.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 95,628.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95,628.3мянган төгрөг буюу 98.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 500.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр өгсөн байна.

Үүнээс томилолт зардалд 500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллийг хугацаандаа шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ыг зөрчин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2,182.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг авч ажиллаж 1,277.9 мянган төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2182.5 мянган төгрөгийн алдаа илэрсэнд зөрчил арилгуулахаар албан шаардлага өглөө.

### 4.1 Албан шаардлага

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас цагдаагийн хэсгийн интернэтийн төлбөрт 185.0 мянга, бичиг хэргийн зардалд 32.5 мянга, камерийн кабелийн үнэд 185.0 мянга, бензиний зардалд 1865.0 мянга, нийт 2182.5 мянган төгрөгийн зардлыг тушаал шийдвэргүйгээр зориулалт бусаар зарцуулсан алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | 2182.5 | | | | | 1 | 2182.5 | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:
УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР
АУДИТОР /С.ЦЭРЭНМИНЖИН/

2022 оны 2-р сарын 24-ны өдөр